

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭЛТГЭХ ЭРХ ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ

Энхсайханы Дашгаадан
*Дотоод хэргийн их сургуулийн докторант,
хууль зүйн болон боловсрол судлалын магистр,
цагдаагийн ахлах дэслэгч*
dashgaadan.e@uia.gov.mn

Хураангуй. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Монгол улсын цагдаагийн алба, алба хаагчдын сургалтын үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн хэд хэдэн хууль тогтоомж Монгол улсын Үндсэн хуульд нийцүүлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд “Цагдаагийн албаны тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, “Боловсролын тухай хууль”-иуд нь цагдаагийн алба, алба хаагчдын сургалтын үйл ажиллагааны үндэс болж, эрх зүйн зохицуулалтыг хангаж байна. Мөн үүнээс гадна сургалтын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах үүднээс “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”, “Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагааны журам” зэрэг системчилсэн актуудыг судалгаануудад түшиглэн, гадаадын зарим орны жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдөж эхлээд багагүй хугацаа өнгөрчээ.

Аливаа нийгмийн аюулгүй байдлыг ханган зөрчилдөөнийг шийдвэрлэхэд цагдаагийн байгууллагын алба хаагчид зонхилох үүргийг гүйцэтгэсээр ирсэн. Тэгвэл тэдгээр алба хаагчдын мэдлэг, боловсрол, мэргэжлийн ур чадварыг олгодог сургалт, эрх зүй, зохион байгуулалтыг судлах нь дан ганц тухайн сургалтын хөгжил гэлтгүй улс орны аюулгүй байдлын боловсон хүчний мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Abstract. In order to organize the training activities within the framework of the law, systematic acts such as “Police Procedures” and “University of Internal Affairs Procedures” have been developed and implemented in accordance with the standards of some foreign countries.

Expanding research on the theory, methodology, and legal framework for police training has become an important goal for research institutions and researchers. Police officers have always played a key role in ensuring public safety and resolving conflicts. The study of the training, theory, philosophy, legal and methodological approaches that provide knowledge, education and professional skills to these officers is important not only for the development of the training, but also to determine the knowledge, skills and attitudes.

Түлхүүр үг: Е.

Удиртгал. Цагдаагийн алба хаагчийг бэлтгэж, нийгмийн үзэгдэл болох гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад үнэтэй хувь нэмэр оруулах үйл ажиллагаа бол сургалт юм. Цагдаагийн алба, алба хаагчийн хүний нөөцийн бодлогын чиглэлээр олон судалгаа байдаг ч сургалтын чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл Ц.Наранчимэг, С.Хаянгарваа нараар хязгаарлагдаж, харьцангуй цөөн байна.

Харин гадаадын зарим судлаачид буюу Тэзз Ньютон¹, Жулиан Констебль², С.Харрисон³, Иан Пеппер⁴, Викториа Гибсон⁵, Яйэл Литманович⁶, Френк Аллард⁷, Эндрью Хиллс⁸, Перси Меттэр⁹, К.Лин¹⁰, Султан Абдиев¹¹, Хусейн Арас¹², Алпер Нуман¹³ нар цагдаагийн албаны сургалтын талаар докторын зэрэг хамгаалсан байна.

Нөхцөл байдалд зөв арга хэмжээ авах, хуулийн дагуу ажиллах нь цагдаагийн алба хаагчийн хамгийн чухал чадвар. Нөгөөтэйгүүр тэдний боловсон хүчнийг бэлтгэхэд хууль эрх зүйн зохицуулалт хэрхэн нөлөөлдөг, практикт болон академик салбарт суралцагч ба алба хаагчийг хөгжүүлэхэд эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй, мөн сургалтын үйл ажиллагааны цогц байдал хангагдахгүй байна гэсэн таамгийг батлахаар зорьлоо.

1. Цагдаагийн алба, алба хаагчдын сургалтын тухай ойлголт

1.1. Цагдаагийн алба хаагчийн сургалт, уламжлал

Сургалт бол багшийн сурган хүмүүжүүлэх болон суралцагчийн сурч танин мэдэх үйл ажиллагааны нэгдэл гэж үздэг.¹⁴ Сургалт бол нийгмийн болон суралцагчийн эрэлт хэрэгцээг хангах зорилго бүхий багшийн сургах, суралцагчдын сурах хамтын бүтээлч үйл ажиллагаа юм.¹⁵ Сургалтын тухай төгс бүрэн тодорхойлолт гарган түүнийг баримтлах нь боломжгүй зүйл бөгөөд сургагч багш нар судлаач эрдэмтэн бүгд өөр өөрийн тодорхойлолттой байдаг нь ардчилсан нийгэмд хөгжлийн гол хөдөлгүүр болж байна.

Сургалтын онолыг нийгэмд тавигдаж байгаа шаардлага, цаг үе, улс орон, хүмүүсийн сэтгэлгээнд хүлээн зөвшөөрөгдөөд байгаа шинэ соёл иргэншилтэй холбож өгөх нь чухал. Япон, Солонгос зэрэг боловсролын салбар өндөр хөгжсөн улс сургалтынхаа агуулгаар илүү гүн ухааны онолын чиг хандлагыг баримталж, нийгмийн хүчин зүйлд хоцролгүй өөрчлөлт оруулж ирсэн ба пост модернист гүн ухааны урсгалыг

¹ Newton, Tess. Reducing miscarriages of justice : police training and the development of 'ethical' interviewing. 1999. University of Wales.Cardiff

² Constable, Julian. Continuity and change in initial police training : a longitudinal case study. 2017. Anglia Ruskin University

³ Harrison, C. W. The reality of police professionalism : a sociological investigation into recruitment, training and promotion in a metropolitan county police force. 1988. University of Sheffield

⁴ Pepper, Ian K. The initial education and training of tomorrow's police workforce today and today's police workforce for tomorrow. 2013. University of Sunderland

⁵ Gibson, Victoria. An investigation into training evaluation : the case of the police. 2012. Manchester Metropolitan University

⁶ Litmanovitz, Yael D. Moving towards an evidence-base of democratic police training : the development and evaluation of a complex social intervention in the Israeli Border Police. 2016. University of Oxford

⁷ Allard, Frank Dennis. Police probationer training : policy and practice an historical review. 1997. University of Hull

⁸ Hills, Andrew. A case study to investigate the application of programme evaluation theory to the Metropolitan Police Diversity Training Programme. 2005. University of Hull

⁹ Mather, Percy. An examination of the effectiveness of initial training for new police recruits in promoting appropriate attitudes and behaviour for twenty first century policing. 2012. University of Newcastle

¹⁰ Lin, K.-H. Towards democratic policing in Taiwan : a longitudinal study of the effects of police education on human rights, moral reasoning, prejudice and receptivity to evidence-based policing. 2020. University College London

¹¹ Sultan ABDİEV. Case-based learning method in contemporary police education: Development and testing a model at the Turkish National Police Academy. 2013

¹² Hüseyin ARAS. Police education and cultural diversity in Turkey. 2016

¹³ Alper NUMAN. The thematical analysis of Turkish national police education before active service in terms of democratization and modernization in the process of full membership of European Union.2013

¹⁴ Edward Lindeman. Насанд хүрэгчдийн боловсролын утга учир

¹⁵ Ичинхорлоо. Ш.Сургалтын гарын авлага. УБ.2013. 3 дахь тал

цаг алдалгүй өөрийн орны сургалтын онолд хослуулсан нь техник технологийн хөгжилд хүчтэй нөлөөлсөн байна.

Дээд боловсролын шинэчлэлд дэлхийн хандлагыг авч үзэхдээ боловсролын либералчлалыг анхаарвал зохино. Учир нь боловсрол олгох үйл явц, агуулгын хандлага нь аль болох интерактив буюу олон талт харилцаанд суурилсан, уян хатан шинжтэй хөгжиж байгаа хамгийн либерал систем юм.¹⁶

Сонсогчид өөрсдийн сурах арга барилтай байдаг нь хувь хүний амьдралын явцад төлөвшсөн зан төлөв, амьдралын нөхцөл, өмнөх туршлага гээд олон зүйлээс хамаарна. Иймд сургагч багш, чиглүүлэгч, дэмжигчийн зүгээс хүн бүрт тохирсон арга барилаар ажиллах, тухайн хүний мэдлэг ур чадвар, хэрэгцээнд тулгуурлан өөр өөрийнх нь боломжийг нээхэд чиглүүлсэн үйл ажиллагаа явуулах нь чухал юм. Хэрэв ингэж чадахгүй бол үл ойлголцол, тоомжиргүй хандах, сорьж шалгах, итгэлгүй болох зэрэг бэрхшээлүүд үүсдэг.¹⁷

Цагдаагийн алба хаагч болохоор бэлтгэгдэж байгаа сонсогчид сурч эхлэхээсээ өмнө өөрт юу хэрэгтэйгээ сайтар мэдэрч, өөрийн хэрэгцээнд тулгуурлан сонголтоо хийсэн байдаг. Учир нь цагдаагийн алба хаагч нь ажлын нөхцөл байдал, онцлогоос шалтгаалж маш хүнд мэргэжлийн ангилалд ордог.¹⁸

Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.¹⁹ Тэгвэл энэхүү тусгай үүргийг гүйцэтгэдэг төрийн алба хаагчийг бэлтгэх сургалт нь өөрийн онцлогтой байдаг.

Андрогогикаг насанд хүрэгчдийг сургах үзэл орчин үед суралцагч төвтэй сургалтын үзэл санаа дэлгэрч, сургалт нь багшийн сурган хүмүүжүүлэх болон суралцагчийн сурч танин мэдэх үйл ажиллагааны нэгдэл гэж үзэх болсон²⁰.

Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх сургалт нь нэг талаасаа насанд хүрэгчдийн сургалт юм. Иймээс энэхүү сургалтын онцлог, анхаарах асуудлыг судалж үзэх нь судалгааны ажлын үндсэн дүгнэлтэд чухал ач холбогдолтой байна.

Насанд хүрэгчдийн сургалт нь хэд хэдэн онцлогтой байдаг. Тухайлбал насанд хүрэгч бол сайн дурын суралцагч буюу өөрт юу хэрэгтэй байна түүнийгээ сурахыг эрхэмлэдэг. Мөн тодорхой хэмжээний дадлага туршлага хуримтлуулсан байдгаараа онцлогтой.

Манай орны хувьд цагдааг бэлтгэж ирсэн сургалт дотоодыг хамгаалах газрын “Төв сургууль” анх 1934 онд байгуулагдсан ба түүхэн үйл явцын хугацаанд цагдаа, дотоодын цэргийн байгууллага, хилийн цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, онцгой байдал, шүүхийн шинжилгээний үндэсний төв зэрэг төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдын бэлтгэж ирсэн байна.

1934-1965 онд Дотоодыг хамгаалах газрын төв сургуулиас Дотоод явдлын яамны хязгаар ба Дотоодын цэргийн нэгдсэн сургууль, 1965-1982 онд Цэргийн ерөнхий дээд сургуулийн дэргэд цагдан сэргийлэх байгууллагад хуульч мэргэжилтэн бэлтгэж байгаад НАХЯ-ны Цэргийн тусгай дунд сургууль байгуулан улмаар хилийн цэрэг, цагдан

¹⁶ Дээд боловсролын онол, арга зүй

¹⁷ Даваа, Ж. Сургалтын технологи. УБ. 2017

¹⁸ Başar, H. Sınıf Yönetimi. Ankara: Milli Eğitim Bakanlığı Yayınları No., 2009

¹⁹ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

²⁰ Edward Lindeman., (2001), Насанд хүрэгчдийн боловсролын утга учир

сэргийлэх, засан хүмүүжүүлэх байгууллагад ажиллах цэргийн ба хуулийн дунд мэргэжлийн хуульч, офицеруудыг бэлтгэж байсан байна.

1982-2000 онд НАХЯ-ны Цэргийн дээд сургуулиас Цагдаагийн дээд сургууль болж, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, гал түймэртэй тэмцэх байгууллагын дээд боловсролтой боловсон хүчнийг бэлтгэж байсан.

Харин 2012 онд Дотоод хэргийн их сургууль болж, аюулгүй байдал, хууль зүй дотоод хэргийн салбарын тусгай алба хаагчдыг бэлтгэдэг их сургууль болон өргөжсөн төдийгүй цагдаагийн сургууль нь бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж, өөрсдийн сургалтын үйл ажиллагааг тодорхойлж, ахлагч болон ахисан шатны сургалтын хөтөлбөрүүдийг ялгаж тус тусын сургуульд хэрэгжүүлж байгаа нь онцлогтой болжээ²¹.

Энэ утгаараа Монгол улсын түүхэн, ууган их сургуулийн бүрэлдэхүүн хэсэг болсон цагдаагийн сургууль цагдаагийн алба хаагчдыг түүхэн онц цаг хугацаанд тасралтгүй бэлтгэсээр иржээ.

1.2. Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх эрх зүйн зохицуулалт

Цагдаагийн дээд боловсрол олгох тогтолцооны хувьд 2014-2015 оны хичээлийн жилээс өмнө “Цагдаагийн ажил-эрх зүй” мэргэжлээр суралцаж, эрх зүйн бакалавр зэрэгтэй төгсөгчдийг цагдаагийн албад томилон ажиллуулж ирсэн билээ. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78 дугаар тушаалаар “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл, индексийн жагсаалт”-ийг шинэчлэн баталснаар “Эрх зүй” ба Цагдаа-хууль сахиулах ажил сургалтын хөтөлбөрүүд нь ерөнхий болон төрөлжсөн чиглэлийн хувьд өөр ангилалд хамаарч, одоо төгсөгч нь энгийн салбарт хөрвөх боломжгүй, цагдаагийн дээд боловсрол эзэмшиж байна.

Энэ нь сургалтын хөтөлбөрөөр төгсөгчийн эзэмших цогц чадамжийн хүрээг өөрчилж, мэдлэг, ур чадварын хосолсон сургалтын хэлбэрээс ур чадвар, үр дүнд суурилсан сургалтын хэлбэрт шилжих үндсэн нөхцөлийг бүрдүүлж, Цагдаа-хууль сахиулах ажил хөтөлбөрийг 2015 оноос үе шаттайгаар шинэчлэн боловсруулах ажлыг хийж гүйцэтгэхэд хүргэсэн юм.

Гэвч төгсөгчдийн ажлын байранд гүйцэтгэж буй үйл ажиллагаа нь хүний эрхийг хангах, хамгаалах, хуулийг нэг мөр хэлбэрэлтгүйгээр сахин биелүүлэх, хэрэгжүүлэхэд чиглэгдэж байгаа байдал зэрэгтэй нь холбогдуулан цагдаагийн алба хаагчийг бэлтгэж буй дээд боловсролын мэргэжлийн чиглэлийг Цагдаагийн ажил-эрх зүй болгон өөрчлөх саналыг захиалагч байгууллага удаа дараа тавьж ирлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 152 дугаар тогтоолоор Хууль сахиулахын их сургуулийг Дотоод хэргийн их сургууль болгон өөрчлөн зохион байгуулж, Их сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулга, чанарыг дээшлүүлэх, багшлах бүрэлдэхүүнийг чадваржуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдад тус тус даалгасан байна.

Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг өөрчлөх ажлын хэсэг байгуулагдаж, 2 шатлалт 6 жилийн сургалтын хөтөлбөрийг өөрчилж, 4 жилийн сургалттай хөтөлбөрт шилжүүлэх саналыг

²¹ Дотоод хэргийн их сургуулийн түүхэн хураангуй. УБ.2019

Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулж, сайдын 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/183 дугаар “Сургалтын хөтөлбөрийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тушаал гарч, ажлын хэсгийн шийдвэрийг баталгаажуулсан.

Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/336 дугаар тушаалаар “Мэргэжлийн чиглэл, индекс төрчлөлт оруулах тухай” шийдвэр гарч, энэ шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд D103201 индекстэй “Цагдаагийн ажил-эрх зүй” хөтөлбөрийг шинээр боловсруулан 2019-2020 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлжээ.

Харин цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалтын талаар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 118.7-д авч үзсэн байна. Эдгээр сургалтын цагдаагийн төв байгууллагын сургалтын хэлтэс, их дээд сургуультай хамтран эсвэл сургалтын ажил хариуцсан нэгж, бүсийн сургалтыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хариуцахаар зохицуулжээ.

Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн бэлтгэл нь цагдаагийн алба хаагчаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэх мэдлэг, ур чадварыг олгоход чиглэх ба эдгээр нь:

- мэргэшүүлэх сургалт
- ур чадварын сургалт
- чадавхжуулах сургалт
- албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадварын сургалт ёс зүйн сургалт зэргээс бүрдэнэ.

Үүнээс үзвэл эрх зүйн зохицуулалтын хувьд цагдаагийн алба хаагчийг бэлтгэж байгаа сургалтын үйл ажиллагаа, практикт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийг мэргэшүүлэх сургалтын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө ялгаатай, үйл ажиллагаа явуулах чадамж, туршлага эрс ялгаатай байна. Мөн сургалтын үйл ажиллагаанд аль аль байгууллагын төлөөлөл оролцож, хөтөлбөр, төлөвлөгөөг баталж байх зохицуулалттай ч хэрэгждэггүй байна.

2. Цагдаагийн алба, алба хаагчийг бэлтгэхэд анхаарах асуудлууд

2.1. Цагдаагийн сургуулийн сургалт, албаны сургалтын баримт бичгийн судалгаа

Сургалтын технологийг шинэчлэх ажлын хүрээнд Сургалтын технологи, арга зүйг олон улсын жишигт ойртуулах, академик сургалт давамгайлсан хөтөлбөрөөс прагматик буюу чадваржуулах сургалт давамгайлсан хөтөлбөрт шилжих, чадваржуулах сургалтын шинэ технологийг судлан нутагшуулах, мэдээллийн технологийн ололтод тулгуурласан цахим сургалтын технологийг нэвтрүүлэх чиглэлээр тодорхой ажлууд төлөвлөн хэрэгжүүлсээр байна.

Тухайлбал, мэргэжлийн үйл ажиллагааг бие даан хэрэгжүүлэх чадвар эзэмшүүлэх чадамжид суурилсан модуль сургалт, мэргэжлийн мэдлэг, чадварыг цогцоор нь эзэмшүүлэх, хичээлүүдийн сэдвүүдийн уялдаа холбоог харгалзан зохион байгуулах блок сургалт, захиалагч байгууллагыг түшиглэн мэргэжлийн үйл ажиллагааны бодит орчинд мэргэжилтэн-багшийг дагалдуулан сургах клиник сургалт, бодит нөхцөл байдалд ойртуулан зохиомжилсон орон зайд мэргэжлийн үйл ажиллагааг бие даан болон багаар хэрэгжүүлэх сургалтын тоглолт, орон зай, цаг хугацаанаас үл хамааран зохион байгуулах мэдээллийн технологид суурилсан цахим /online/ сургалт зэрэг сургалтын технологиудыг өмнөх туршлага дээрээ тулгуурлан хөгжүүлж, ижил төрлийн сургалт явуулдаг гадаад,

дотоодын их, дээд сургуулиудын туршлагыг судлан нутагшуулах, шинээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах шаардлага тулгарч байна.

Нөгөөтэйгүүр сонсогч суралцагч төгсөхдөө тухайн албан тушаал дээр тавигдсан шаардлагад хэр нийцэж байгаа, өдөр тутмын үйл ажиллагааг хийж гүйцэтгэх хангалттай чадвартай төгсөж байгаа эсэхэд нарийвчилсан судалгаа, шинжилгээ хийгдэхгүй байна. Мөн төгссөний дараахь албаны, давтан, мэргэшүүлэх сургалтууд нь үндсэн сургалтын үйл ажиллагаатай уялдаа, хамтран гүйцэтгэх нөхцөл байдлаар хомс байна.

График №2



график №3



График 1,2. Сургалтын багц цаг, хичээлийн харьцуулалт.

Батлагдсан сургалтын хөтөлбөрүүдэд суралцагчдын сонгон судлах багц цагийн харьцуулалтаас үзвэл ерөнхий суурь чиглэлийн 4 багц цагийн, мэргэжлийн суурь чиглэлийн 2 багц цагийн, мэргэжлийн чиглэлийн 12-14 багц цагийн хичээлийг сонгон судлуулахаар төлөвлөжээ.²²



График 3. Сургалтын танхим, дадлагын цаг.

Алба хаагчдын давтан болон мэргэшүүлэх сургалтыг 2014 оноос өмнө жилүүдэд тухайн үеийн Хууль сахиулахын их сургууль дээр зохион байгуулж байсан бол 2014 оноос Цагдаа дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийг байгуулж тус төв дээр сургалтууд тусгайлан бэлтгэсэн удирдамж, төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явагдаж байна.

Сургалтын төв нь:

- Гэмт хэрэгтэй тэмцэх
- Нийтийн хэв журам хамгаалах
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах
- Удирдах ажилтны

²² Цагдаагийн сургуулийн 2020 оны тайлангаас хэсэгчилэн авав.

- Давтан болон албан тушаалтны
- Бусад гэсэн чиглэлээр хөтөлбөр боловсруулж сургалт явуулдаг.

Цагдаагийн албаны сургалт тус сургалтын төвд 2020 онд 95 удаагийн сургалтад давхардсан тоогоор 7806 алба хаагчийг, иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны 20 удаагийн сургалтад 1000, олон нийтийн цагдаагийн ажилтан бэлтгэх 2 удаагийн сургалтад 60, гэрээт харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх 4 удаагийн сургалтад 150 иргэнийг, нийт 121 удаагийн сургалтад 9016 алба хаагч, иргэн хамрагдахаар төлөвлөгдсөн.²³

2021 оны эхний хагас жилийн байдлаар 94 удаагийн 1365 цагийн сургалт /танхимаар 18, зайны, цахим хэлбэрээр 71, зайн 5/-ыг зохион байгуулж, 923 иргэн, 7470 алба хаагч, нийт 8393 алба хаагч, иргэнийг хамруулсан байна.²⁴

Хүснэгт 1. Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн 2020 оны сургалтын задаргаа

№	Чиглэл	Давтамж	Хамрагдсан тоо
1	Давтан, мэргэшүүлэх	95	7806
2	Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагаа	20	1000
3	Олон нийтийн цагдаа	2	60
4	Гэрээт харуул хамгаалалтын ажилтан	4	150
5	Нийт	121	9016

Цагдаа дотоодын цэргийн сургалтын төвийн үйл ажиллагааны дүнгээс авч үзвэл жил бүр тодорхой сэдвүүдээр, тодорхой тооны алба хаагчдад сургалтыг зохион явуулахаар төлөвлөдөг. Гэвч цар тахал болон бусад шалтгаанаар зарим танхимын сургалт төлөвлөгөөний дагуу явагддаггүй бөгөөд сургалтын төвийн мэргэжилтэн алба хаагчийн орон тоо бага, цахим зайн сургалтыг техник технологи, чанар стандартын дагуу зохион байгуулах чадвар чадамж хомс байдаг зэргээс сургалт явуулах үйл ажиллагаа тасалддаг байна. Мөн сургалтад цагдаагийн байгууллагын бүх алба хаагч хамрагдаж чаддаггүй. Учир нь сургалтад хамрагдах алба хаагчдыг цагдаагийн газар хэлтсээс нэрсийг нь өгч хамруулдаг буюу сургалтад суух шаардлагатай, шинээр томилогдсон, сахилга ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдыг онцлон хамруулдаг нь ажиглагдаж байна. Хэдийгээр жилд сургалтад хамрагдаж байгаа алба хаагчдын тоо сүүлийн 4 жилийн дунджаар 7000 орчим байна. Гэвч энэ нь давтагдсан тоо мэдээ юм.

Мөн сургалтын агуулга, хөтөлбөр, заах арга зүй, хичээлийн хэрэглэгдэхүүн, сургагч багш зэргийн үйл ажиллагаа тогтвортой бус, чанар стандартын хувьд учир дутагдалтай байдал ажиглагдаж байна.

Сургалтын үйл ажиллагааны журмын дагуу цагдаагийн дээд боловсролын байгууллага, сургалт хариуцсан нэгжтэй хамтран сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг санал солилцон батлах, хамтран ажиллах чиг үүрэгтэй боловч энэ нөхцөл хангагдахгүй байсаар байна. Орон тооны сургагч багш байхгүй бөгөөд цагдаагийн алба, төрөл мэргэжлийн алба хаагчдыг урьж, гэрээ хийж хичээл сургалтыг зохион байгуулах нь практик туршлагын

²³ Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн 2020 оны төлөвлөгөө

²⁴ Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн 2021 оны хагас жилийн тайлан

мэдээлэл солилцох ач холбогдолтой ч шинэ тутам хичээл сургалтыг заах, сургалт зохион байгуулахад тохиромжтой бус байдал ажиглагдаж байна.

2.2. Цагдаагийн хүний нөөцийг бэлтгэх сургалтын тулгамдаж буй асуудлын талаарх санал асуулгын судалгаа

Цагдаагийн сургуулийн сургалтын үйл ажиллагааны талаар сонсогч, суралцагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгааг авч үзвэл хичээл сургалт, түүнээс гадна бусад үйл ажиллагаанаас шалтгаалсан ачаалал ихтэй, цэрэгжилт жагсаалч байдлыг голлодог, дадлагын сургалтын үр дүн харьцангуй сул үр дүнтэй гардаг нь нууц биш юм.

Харин Цагдаагийн байгууллагын алба хаагчдад зориулсан нээлттэй боловсролын хөтөлбөрт сургалтын талаарх мэдээлэл, хэрэгцээний талаар Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын харьяа 6 хэлтсийн мөрдөгч-22, хэсгийн байцаагч-8, эргүүлийн цагдаа-29 нийт 65 алба хаагчийг оролцуулан фокус ярилцах, асуултад хариулт хэлбэрээр зохион байгуулсан судалгааны үр дүнг нэгтгэн шинжиллээ.

Цагдаагийн байгууллагын алба хаагчдад зориулсан сургалт зайлшгүй хэрэгтэй эсэх асуултад оролцогчдын 41 буюу 63 хувь нь маш чухал, 9 буюу 13.8 хувь нь шаардлагатай, 15 буюу 23 хувь нь шаардлагагүй гэж хариулсан.

Цагдаагийн байгууллагын алба хаагчдын давтан болон мэргэшүүлэх сургалт чанартай явагддаг эсэх гэсэн асуултад оролцогчдын 6 буюу 9.2 хувь нь чанартай, 16 буюу 24.6 хувь нь дундаж, 43 буюу 66.1 хувь нь чанар муу гэж хариулсан.

Албаны сургалтад бүх алба хаагч хамрагддаг эсэх талаар оролцогчдоос бүх алба хаагчид хамрагддаг гэж хариулаагүй, 45 буюу 69.2 хувь нь зарим тохиолдолд, 20 буюу 30.7 хувь нь хамрагддаггүй гэж хариулжээ.

Сургалт хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд тохирдог эсэхийн талаар оролцогчдын 7 буюу 10.7 хувь нь эрэлт хэрэгцээнд нийцдэг, 50 буюу 76.9 хувь нь нийцдэггүй, 8 буюу 12.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

Мөн албаны сургалтад, цагдаагийн сургуулийн сургалтын мэргэжилтнүүд хамтран оролцдог эсэх талаар асуултад дийлэнх нь үгүй гэж хариулсан байна. Албаны сургалтын ямар арга, хэлбэр ашиглагддаг талаар асуултад дийлэнх нь мэдэхгүй гэж хариулав.

Үүнээс гадна сургалтын зохион байгуулалт тааруу, сургалтын төв хол байрладаг, сахилга ёс зүйн зөрчилд холбогдсон алба хаагчдын хүчээр хамруулдаг, мэргэжлийн багш, алба хаагчид сургалтыг зохион байгуулдаггүй, сургалтын багц цаг бага байдаг зэрэг саналуудыг санал асуулгаар тусгасан байв.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд зохион байгуулдаг сургалт алба хаагчдад маш чухал хэдий ч тогтмол биш, тусгай хөтөлбөргүй, хэрэглэгчийн хүлээлт, эрэлтэд нийцдэггүй, арга барил нь хуучирсан ихэвчлэн дарга нар үүрэгддэг, сонирхолгүй, уйтгартай гэсэн таагүй хариултауд нь хүний хүсээгүй зүйлийг хүчээр тулгах нь алба хаагчийн хүсэл тэмүүллийг унтрааж, ажлын үр дүн, бүтээмжийг өсгөх боломжгүй.

Цаашид Цагдаагийн алба хаагчдын хувийн амьдрал, албаны үйл ажиллагаанд нээлттэй боловсролын хөтөлбөрт сургалт²⁵ нь туйлын чухал гэж дүгнэж байна.

2.3. Гадаадын зарим орны цагдаагийн хүний нөөцийг бэлтгэж буй сургалтын хэрэгжилт

²⁵ Open Education Program, Open Educational Resources Programme (OERP: UNESCO)

Ихэнх орнуудад цагдаагийн алба хаагчдыг бэлтгэх сургалтын үйл явц дараах нийтлэг онцлогтой байна. Сургалтын үйл ажиллагааны оролцогчдын үүрэг чиглэл нь журамлагдсан шинжтэй, мэргэшүүлэх хөтөлбөрүүд нь хэрэглээний буюу прагматик сургалтын онол, арга зүйд суурилсан. Ихэнх улс орны цагдаагийн сургалт нь дотуур байранд байрлаж, хичээлдээ хамрагдаж, бие даан суралцах боломжоор хангаж өгдөг. Практик байгууллагын үйл ажиллагаатай байнгын холбоотой ажилладаг.

ОХУ-ын цагдаагийн сургалтын байгууллагын ажиллах журмыг хууль сахиулах албаны журамтай нийцүүлэн мэргэжлийн болон давтан сургалтын нэгдмэл, шаталсан тогтолцоог бүрдүүлж, цагдаагийн боловсролын тогтолцоог шаталсан байдлаар хөгжүүлэх, сургалтын үйл ажиллагаанд орчин үеийн арга барил ашиглах, үр дүнд суурилсан сургалтын хяналт, шинжилгээний тогтолцоог бүрдүүлэх зэрэг цагдаагийн сургалтын тогтолцоог хөгжүүлэхэд анхаардаг.

Европын холбооны улсуудын цагдаагийн сургалт нь ерөнхийдөө цагдаагийн байгууллагынхаа бүтэц зохион байгуулалттай нийцсэн, алба хаагчийн албан тушаалын зэрэглэл өсөх бүр мэдлэг, чадварын үзүүлэлт нь өсөн нэмэгдэх байдлаар төлөвлөгддөг. Цагдаагийн албаны удирдах албан тушаал горилогчид түүнд нийцсэн сургалтад заавал хамрагдсан байх шаардлагатай болдог.

АНУ цагдаагийн алба хаагчдыг бэлтгэхдээ Европын ихэнх орнуудтай харьцуулахад хамаагүй бага цаг зарцуулдаг. АНУ-ын сургалтын үндсэн хөтөлбөрүүд дунджаар хорин нэг долоо хоног үргэлжилдэг бол Европын ижил төстэй хөтөлбөрүүд гурван жилээс илүү үргэлжилдэг²⁶. Финлянд, Норвегид элсэгчид үндэсний коллежид цагдаагийн чиглэлээр суралцаж, тодорхой цагийг орон нутгийн цагдаад дадлага хийж өнгөрөөж, эрүүгийн эрх зүй эсвэл холбогдох чиглэлээр дээд боловсрол эзэмшдэг байна.

Дүгнэлт. Энэхүү өгүүллээр цагдаагийн байгууллагын боловсон хүчнийг бэлтгэхэд хууль эрх зүйн зохицуулалт хэрхэн нөлөөлдөг, практикт болон академик салбарт суралцагч ба алба хаагчийг хөгжүүлэхэд эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй, мөн сургалтын үйл ажиллагааны цогц байдал хангагдахгүй байна гэсэн таамгийг батлахаар зорьсон.

Манай орны хувьд цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнийг 1934 оноос хойш бэлтгэж ирсэн. Цагдаагийн алба хаагчдыг бэлтгэх, практикт ажиллаж байгаа алба хаагчдын давтан болон мэргэшүүлэх сургалтад онолын үүднээс андрогоги болон практикт суурилсан онолоор сургалтыг зохион байгуулж байна.

Сургалтын үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн хэд хэдэн хууль тогтоомж Монгол улсын Үндсэн хуульд нийцүүлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд “Цагдаагийн албаны тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, “Боловсролын тухай хууль”-иуд нь цагдаагийн алба, алба хаагчдын сургалтын үйл ажиллагааны үндэс болж, эрх зүйн зохицуулалтыг хангаж байна. Мөн үүнээс гадна сургалтын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах үүднээс “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”, “Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагааны журам” зэрэг системчилсэн актуудыг судалгаануудад түшиглэн, гадаадын зарим орны жишигт нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлж байна.

Клиник сургалт, бодит нөхцөл байдалд ойртуулан зохиомжилсон орон зайд мэргэжлийн үйл ажиллагааг бие даан болон багаар хэрэгжүүлэх сургалтын тоглолт, орон зай, цаг хугацаанаас үл хамааран зохион байгуулах мэдээллийн технологид суурилсан цахим /online/ сургалт зэрэг сургалтын технологиудыг өмнөх туршлага дээрээ тулгуурлан

²⁶ <https://www.osce.org/files/f/documents/f/7/423401.pdf>

хөгжүүлж, ижил төрлийн сургалт явуулдаг гадаад, дотоодын их, дээд сургуулиудын туршлагыг судлан нутагшуулах, шинээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах шаардлага тулгарч байна. Нөгөөтэйгүүр сонсогч суралцагч төгсөхдөө тухайн албан тушаал дээр тавигдсан шаардлагад хэр нийцэж байгаа, өдөр тутмын үйл ажиллагааг хийж гүйцэтгэх хангалттай чадвартай төгсөж байгаа эсэхэд нарийвчилсан судалгаа, шинжилгээ хийгдэхгүй байна. Мөн төгссөний дараахь албаны, давтан, мэргэшүүлэх сургалтууд нь үндсэн сургалтын үйл ажиллагаатай уялдаа, хамтран гүйцэтгэх нөхцөл байдлаар хомс байна.

Сургалтын үйл ажиллагааны журмын дагуу цагдаагийн дээд боловсролын байгууллага, сургалт хариуцсан нэгжтэй хамтран сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг санал солилцон батлах, хамтран ажиллах чиг үүрэгтэй боловч энэ нөхцөл хангагдахгүй байсаар байна. Орон тооны сургагч багш байхгүй бөгөөд цагдаагийн алба, төрөл мэргэжлийн алба хаагчдыг урьж, гэрээ хийж хичээл сургалтыг зохион байгуулах нь практик туршлагын мэдээлэл солилцох ач холбогдолтой ч шинэ тутам хичээл сургалтыг заах, сургалт зохион байгуулахад тохиромжтой бус байдал нь судалгаагаар авсан баримт, санал асуулгаас ажиглагдаж байна.

Эргэх холбоо нь сургалтын явцад ямар бэрхшээл эсвэл дэвшил гарч буйг мэдэхэд тусалдаг мэдээлэл бөгөөд сургалтын чухал хэрэгсэлд тооцогддог. Алба хаагчдыг бэлтгэн гаргах, ажил дээрх алба хаагчдын сургалтад ямар бэрхшээл тулгарч байгаа талаар сургалтын байгууллага, алба, нэгжүүд харилцан мэдээлэл солилцон, эргэх холбоог хангах, сургалтын үйл ажиллагааны журмыг шинэчлэн хоорондын уялдааг хангах нь нэн чухал асуудал болоод байна.

Сургалтад шинэлэг арга, технологи нэвтрүүлэх чиглэлээр багшлах бүрэлдэхүүнээс идэвх санаачилгатай ажиллаж, хичээлийн жил бүр үзүүлэх, нээлттэй хичээл, онол, арга зүйн семинарыг тогтмол зохион байгуулж, үр дүнг сургалтын чанар, агуулгыг шинэчлэх, арга зүйгээ сайжруулахад ашигладаг ч энэ нь тодорхой чанар, стандартгүй, дүр эсгэсэн байдалтай явагддаг тул үзүүлэх, нээлттэй хичээл, онол, арга зүйн семинараас дэвшүүлсэн санал, ололтыг бусад хичээлд ашиглах нь үр дүнтэй юм.

Санал. Дээрх судалгаанд үндэслэн дараах саналуудыг гаргаж байна. Үүнд:

1. Цагдаагийн алба хаагчдыг бэлтгэх, практикт ажиллаж байгаа алба хаагчдын давтан болон мэргэшүүлэх сургалтын харилцан уялдааг хангах;
2. “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”, “Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагааны журам” зэрэг системчилсэн актуудыг судалгаануудад түшиглэн, гадаадын зарим орны жишигт нийцүүлэн нэмэлт боловсруулалт хийх;
3. Сургалтын үйл ажиллагааны журмын дагуу цагдаагийн дээд боловсролын байгууллага, сургалт хариуцсан нэгжтэй хамтран сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг санал солилцон батлах, хамтран ажиллах чиг үүргийг хангаж ажиллах;
4. Алба хаагчдыг бэлтгэн гаргах, ажил дээрх алба хаагчдын сургалтад ямар бэрхшээл тулгарч байгаа талаар сургалтын байгууллага, алба, нэгжүүд харилцан мэдээлэл солилцон, эргэх холбоог хангах;
5. Сургалтад шинэлэг арга, технологи нэвтрүүлэх чиглэлээр багшлах бүрэлдэхүүнээс идэвх санаачилгатай ажиллаж, хичээлийн жил бүр үзүүлэх, нээлттэй хичээл, онол, арга зүйн семинарыг тогтмол зохион байгуулж, үр дүнг сургалтын чанар, агуулгыг шинэчлэх, арга зүйгээ сайжруулахад ашигладаг энэ нь тодорхой чанар, стандарт загварыг тогтоох зэрэг саналуудыг гаргаж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Ж.Даваа. “Сургалтын технологи”, 2017 он, Улаанбаатар хот.
2. Ш.Ичинхорлоо. Насанд хүрэгчдийн сургалтын гарын авлага. УБ.2013.
3. Е.Батчулуун. “Албан бус болон насанд хүрэгчдийн боловсрол”, 2008 он, Улаанбаатар хот.
4. Н.Наранчимэг. “Насанд хүрэгчдийг сургах онол, арга зүйн зарим асуудал”, 2001 он, Улаанбаатар хот.
5. Дотоод хэргийн их сургуулийн түүхэн хураангуй. 2019
6. A.Hüseyin, B.Fatih, Y.Mehmet. “Türk Polis Eğitiminde Durum Eğitimi Modelinin Uygulanması, Polis Eğitiminde Modern Uygulamalar” , 2012, Ankara.
7. Başar, H. Sınıf Yönetimi. Ankara: Milli Eğitim Bakanlığı Yayınları No., 2009
8. M.Knowles. A Theory of Adult Learning: Androgogy, The Adult Learner: A Neglected Species, 4th Ed., Houston: Gulf Publishing Company, 1990
9. E.Lindeman. “Насанд хүрэгчдийн боловсролын утга учир”, 2001 он
10. K.Ahmet. Polis Eğitiminde Vakaya Dayalı Öğretim Uygulamasının Farklı Davranış Biçimleri Geliştirmeye Etki-si, Polis Eğitiminde Modern Uygulamalar, 2012. Ankara
11. A.Hüseyin, B.Fatih, Y.Mehmet. Türk Polis Eğitiminde Durum Eğitimi Modelinin Uygulanması, Polis Eğitiminde Modern Uygulamalar, 2012, Ankara
12. Newton, Tess. Reducing miscarriages of justice : police training and the development of 'ethical' interviewing. 1999. University of Wales.Cardiff
13. Constable, Julian. Continuity and change in initial police training : a longitudinal case study. 2017. Anglia Ruskin University
14. Harrison, C. W. The reality of police professionalism : a sociological investigation into recruitment, training and promotion in a metropolitan county police force. 1988. University of Sheffield
15. Pepper, Ian K. The initial education and training of tomorrow's police workforce today and today's police workforce for tomorrow. 2013. University of Sunderland
16. Gibson, Victoria. An investigation into training evaluation : the case of the police. 2012. Manchester Metropolitan University
17. Litmanovitz, Yael D. Moving towards an evidence-base of democratic police training : the development and evaluation of a complex social intervention in the Israeli Border Police. 2016. University of Oxford
18. Allard, Frank Dennis. Police probationer training : policy and practice an historical review. 1997. University of Hull
19. Hills, Andrew. A case study to investigate the application of programme evaluation theory to the Metropolitan Police Diversity Training Programme. 2005. University of Hull
20. Mather, Percy. An examination of the effectiveness of initial training for new police recruits in promoting appropriate attitudes and behaviour for twenty first century policing. 2012. University of Newcastle
21. Lin, K.-H. Towards democratic policing in Taiwan : a longitudinal study of the effects of police education on human rights, moral reasoning, prejudice and receptivity to evidence-based policing. 2020. University College London
22. Sultan ABDİEV. Case-based learning method in contemporary police education: Development and testing a model at the Turkish National Police Academy. 2013

23. Hüseyin ARAS. Police education and cultural diversity in Turkey. 2016
24. Alper NUMAN. The thematical analysis of Turkish national police education before active service in terms of democratization and modernization in the process of full membership of European Union.2013
25. Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх журам
26. <https://www.osce.org/files/f/documents/f/7/423401.pdf>
27. <https://bjs.ojp.gov/content/pub/pdf/slleta13.pdf>